



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 281

Улаанбаатар хот

Хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ын 3.1, 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мобифинанс ББСБ” ХХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргах 12 сарын хугацаатай, жилийн 14.4 хувийн хүүтэй, нэг бүр нь 1,000,000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,000 /нэг мянга/ ширхэг хаалттай өрийн бичгийг нэмж бүртгэсүгэй.
2. Хаалттай өрийн бичиг гаргахтай холбогдуулан хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Мобифинанс ББСБ” ХХК /Б.Үнэнбат/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН